



## СУРАЛЦАГЧДЫН ЯЛГААТАЙ БАЙДЛЫГ ХАРГАЛЗАН, “МИНИ” ХИЧЭЭЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГЫГ ТУРШСАН НЬ (Багшийн сургуулийн нийгмийн ухааны арга зүйн хичээлийн жишээн дээр)

Н. Үүрийнтуяа<sup>a</sup><sup>a</sup>МУБИС-Багшийн сургууль, багш, магистрХолбоо барих зохиогч: uuriintuya@msue.edu.mn 

Хүлээн авсан: 2024.08.25

Хянагдсан: 2024.09.20

Зөвшөөрсөн: 2024.10.25

### Хураангуй

Багшийн сургуулийн “Хүн нийгэм” буюу нийгмийн ухааны арга зүйн хичээлийн хүрээнд оюутны онцлог, сонирхол зэрэгт тулгуурлаж ялгаатай байдлыг харгалзан “Мини” хичээл зохион байгуулах аргыг боловсруулан туршсан үр дүнгээ энэхүү өгүүллээр танилцуулахыг зорилоо. Судалгаанд багш бага боловсролын хөтөлбөрийн дөрөвдүгээр дамжааны хоёр бүлгийн нийт 53 оюутан хамрагдсан. Оюутан бүрийн ялгаатай байдлыг харгалзан ажиллахад голлон анхаарч судалгаандаа Ховард Гарднерийн оюун ухааныг хөгжүүлэх цогц тестээр суралцагчдын ялгааг илрүүлэх нь чухал гэдгийг онцолж байна.

Судалгааны үр дүнгээс харахад “Мини” хичээлийг дүрд тоглох арга зүйг үр дүнтэй зохион байгуулах, нарийн төлөвлөх, системтэй заах, хэлэлцүүлэг өрнүүлэх нь чухал гэдэг нь судалгааны явцаас ажигласан. Дэвшүүлсэн зорилтынхоо хүрээнд өнөө цагт сургалтын чанар, үр дүнг дээшлүүлэхийн тулд суралцагч бүрийн ялгаатай байдлыг харгалзсан хичээл, үйл ажиллагааг зохион байгуулах дэлхий нийтийн чиг хандлага, эрдэмтэн судлаачдын онол, үзэл баримтлалыг өөрсдийн сургалтын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх зарим боломжийг түгээн дэлгэрүүлэхийг зорилоо.

### Түлхүүр үг

Ялгаатай байдлыг харгалзан сургах, Мини хичээл, Суралцахуйн загвар, Жендэрийн нөлөөллийг тооцсон хичээл төлөвлөлт, Нийгэм соёлын ялгааг, Суралцах хэв шинжийн ялгаа

### Удиртгал

Хүмүүнлэг ардчилсан нийгмийн байгуулсан цагаас хойш Монголын боловсролын орчин, сургалтын тогтолцоо эрс өөрчлөгдсөн. Гэсэн хэдий ч суралцагчдын ялгаатай байдлыг төдийлөн харгалзахгүй байгаа нь тулгамдсан асуудлын нэг хэвээр байсаар

байна. Багш бэлтгэдэг ууган сургуулийн нэг МУБИС-ийн багш нар хамтран суралцагчдын ялгаатай байдлыг харгалзан ажиллах талаар төсөл хэрэгжүүлсэн. Энэхүү төслийн гол зорилго нь ялгаатай байдлыг харгалзах боловсролын онол, арга зүйг боловсруулж түгээн дэлгэрүүлэхээс гадна уламжлалт заах загвараас сурагч нэг бүрийн өвөрмөц сурах чадварыг дээдэлсэн хүртээмжтэй арга барил руу шилжсэн. Орчин үеийн багш нар тэр тусмаа бага ангийн багш нь бага насны хүүхдийн ялгаатай байдлыг судлах, түүнд тохирсон сургах, хүмүүжүүлэх үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, сургалтын үйл ажиллагаагаа төлөвлөж сурах нь багшийн хамгийн чухал чадвар гэж үзэж байна. Сургах үйл ажиллагааны хамгийн анхны алхам бол суралцагчдынхаа онцлог, ялгаатай байдлыг судлах, ангийн зохион байгуулалтыг сайтар тооцоолох явдал юм. Бид туршилт судалгааны ажлаа үе шаттайгаар зохион байгуулсан. Үүнд:

Үйл ажиллагаа-1. Туршилтыг эхлэхийн өмнө бэлтгэл ажлыг төлөвлөх.

Үйл ажиллагаа-2. Ховард Гарднерийн оюун ухааны цогц хөгжлийн сорил авч, боловсруулах

Үйл ажиллагаа-3. "Мини" хичээл зохион байгуулах аргачлал боловсруулан турших.

Үйл ажиллагаа-4. Суралцагчдынхаа ялгаатай байдлыг харгалзсан хичээл төлөвлөх, зохион байгуулах, хэлэлцүүлэг хийх, үр дүнгээ тооцсон. Ийнхүү судалгаа, шинжилгээнд тулгуурлан туршилт хичээлийг төлөвлөн ялгаатайд ялгаатай хандах зарчмаар сургалтын үйл ажиллагааг хөтлөн явуулж, туршлага судлан, "Мини" хичээл зохион байгуулан туршиж, үр дүнгээ тооцсон болно.

## Судалгааны хэсэг

Суралцагчдын ялгаатай байдлыг харгалзсан сургалтыг зохион байгуулахад багшийн үүрэг, хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь уламжлалт сургалтын хэлбэрээс ихээхэн ялгаатай. Энэ талаар дэлхийн олон судлаачид өөр өөрийн үзэл санаагаа илэрхийлсэн байдаг. Эдгээрээс АНУ-ын эрдэмтэн Карол Анн Томлинсон, Жон Хаттие нарын үзэл санаа, сургалтын загварыг орчин үед боловсролын салбарт хамгийн түгээмэл хэрэглэж байна. Томлинсон "Суралцагч бүр сурах ялгаатай байдал, эзэмшсэн мэдлэг, амьдралын туршлага, сурах хүсэл сонирхлоороо өөр өөр байдаг тул сургалтыг зохион байгуулж буй багш суралцагчдад өөрсдөд нь тохирсон харилцан адилгүй заавар зөвлөгөө, дасгал даалгавар өгөх нь зүйтэй" гэсэн үзэл санааг боловсруулжээ. Энэ үзэл санаагаа "Нэг хэмжээтэй гутал бүх хүнд таардаггүй" тул үйлдвэрлэгчид хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлдэгтэй адил "Боловсролын салбарынхан суралцагч бүрийн ялгаатай байдалд тохирсон сургалтыг зохион байгуулах ёстой" хэмээн тайлбарласан. Тэрээр суралцагч бүр хэл, соёл, арьс өнгө, шашин шүтлэг, яс үндэс, гарал үүсэл, нийгмийн байдал, гэр бүлийн хувьд өөр өөр байдаг. Гэтэл боловсролын салбарынхны нэг алдаа бол энэхүү ялгаатай байдлыг харгалзалгүй хүн бүрд тэгш хүртээх зорилготой сургалтын арга зүйг хэрэглэдэг явдал (Tomlison С., 1999). Чухам тиймийн учир уг туршилт хичээлийг зохион байгуулсан билээ.

*Зорилго:* Бага боловсролын багш мэргэжлээр суралцаж буй оюутнуудын ялгаатай байдлыг судалж илрүүлэх, тэдэнд тохирсон мини хичээлийг зохион байгуулах аргыг боловсруулах, төлөвлөх, турших.


Бид судалгаа хийхдээ дараах хоёр алхмын дагуу хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Судалгаа 1-ийн хүрээнд оюутнуудын оюун ухааны зонхилох чадамжийг тодорхойлсон.

Судалгаа 2-ийн хүрээнд оюун ухааны зонхилох чадамжид тулгуурлан “Мини” хичээл зохион байгуулах, хэрэгжүүлэх туршилт судалгааг хийж гүйцэтгэсэн.

Судалгааны үр дүнг график 1-ээс үзнэ үү!

График 1. Оюутнуудын олон талт оюун ухааны зонхилох чадамжийн харьцуулалт, үр дүн



Дээрх судалгааны үр дүнд 4-1 бүлгийн оюутнуудын хүний дотоод соёл, өөрийгөө удирдах чадамж хамгийн өндөр байсан ба орон зайн чадамж хамгийн тааруу хөгжсөн нь үзүүлэлтээс харагдаж байлаа. 4-2 бүлгийн хувьд өмнөх бүлгийн оюутнуудын адил хүний дотоод соёл, өөрийгөө удирдах чадамж хамгийн өндөр байсан бөгөөд хөгжмийн чадамж хамгийн сул хөгжсөн үзүүлэлт ажиглагдсан. Оюутнууд өөрийгөө удирдах чадвар, хувь хүн хоорондын харилцааны чадвар, байгаль хамгаалах ур чадвар нь илүү өндөр байгаа нь дээрх үзүүлэлтээс тодорхой харагдаж байна. Бусад чадамжууд ойролцоо жигд байна тухайлбал, хэл яриа, логик математик, орон зай, бие бялдар, хөгжмийн чадамж зэргийг нэрлэж болохоор байна.

Бага ангийн багш мэргэжлээр суралцагчдын олонх нь хүний дотоод соёл өөрийгөө удирдах чадамж хамгийн өндөр хөгжсөн бөгөөд хүмүүс хоорондын харилцаа, байгалиа хайрлан хамгаалах чадамжууд нэлээд өндөр хувьтай байсан. Мөн судалгааны дүнгээс харахад нийт оюутны хэл ярианы, логик математикийн, орон зайн, бие бялдарын, хөгжмийн гээд бусад чадамжууд жигдхэн хөгжсөн нь тус судалгаанаас харагдаж байна. Бага ангийн багш мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудыг бусад мэргэжлийн оюутнуудтай харьцуулахад математик, байгалийн ухаан, хэл шинжлэл, нийгэм, хүмүүнлэгийн ухаан, биеэн тамир, дүрслэх урлаг, технологи, хөгжим гэх мэт олон төрлийн хичээлүүдийг судладаг нь энэхүү үзүүлэлтэд нөлөөлсөн байж болох талтай. Тэдний оюун ухааны цогц хөгжлийн чадамж ямар байгааг семинарын бүлгээр харуулбал: Бүлэг бүрд харилцан адилгүй

ялгаатай байдал илэрсэн. Тиймээс мэдээллийг цаашид туршилт хичээл төлөвлөх, хичээл зохион байгуулах, бие даах ажлын арга төлөвлөхдөө ашигласан болно. Дээрх судалгааны үр дүнд “Мини” хичээлийн арга зүйг туршихдаа суралцагчдынхаа сонирхол, суралцахуйн ялгаатай байдалд тулгуурлан хичээлийг төлөвлөхөд анхаарал хандуулсан. Бид доорх ойлголтуудыг хичээлийн үйл явц бүрд тусгахад анхаарч ажилласан.

- Янз бүрийн авьяас, ур чадвар бүхий холимог бүлэг
- Суралцах чадварын түвшин
- Жендэрийн нөлөөллийг тооцсон хичээл төлөвлөлт
- Нийгэм соёлын ялгаа

Бид дараах 3 үе шаттай туршилт судалгааг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

**Үйл ажиллагаа 1.** Туршилт хичээлийг зохион байгуулахын өмнөх бэлтгэл ажил:

*Алхам 1.* Оюутнуудын оюун ухааны зонхилох чадамжийг тодорхойлсон туршилт судалгаа хийсэн.

*Алхам 2.* Семинарын хичээлийн бүлгийг 4 дэх өдрийн 1-р цагт хичээл ордог бүлгийг 4-1 бүлэг, 4 өдрийн 2-р цагт хичээллэдэг бүлгийг 4-2 бүлэг гэж кодолсон.

*Алхам 3.* Бүлэг тус бүрийн оюутнууд хичээл зохион байгуулах багийг өөр өөрөөр шийдэж байв.

А. 4-1 бүлэг нийт 27 оюутантай бөгөөд А баг 13 гишүүн, Б баг 14 гишүүнтэй үндсэн 2 том багаар хичээллэхээр төлөвлөсөн.

Б. 4-2 бүлэг нийт 26 оюутантай бөгөөд хос хосоороо буюу 2 хүний бүрэлдэхүүнтэй 13 жижиг багт хуваагдсан.

*Алхам 4.* Хичээлийн туршилтыг зохион байгуулах талаар бүлгийн оюутнуудтай харилцан ярилцаж, тэднээс санал авч, семинарын хичээлийг сонирхолтой, чанартай, хүн бүрийн оролцоог хангах мөн хичээлийн ерөнхий дэг зэргийг хамтран хэлэлцэн тохирсон.

*Алхам 5.* Багаар ажиллах аргачлал боловсруулж, оюутнуудад танилцуулж, хэлэлцсэн.

- Хувь хүний сонирхол
- Суралцах ялгаатай хэв шинж
- Хамтран ажиллах сонголтыг бий болгох зэрэгт анхаарлаа хандуулсан.

*Алхам 6.* Багшийн зүгээс суралцагчдын ялгаатай байдлыг харгалзсан сургалт, анги танхимын менежмент хэмээх төслийн зорилго, ач холбогдол зэргийг товч танилцуулсан.

*Алхам 7.* Суралцагчдын ялгаатай байдал, жендэрийн нөлөөллийг тооцсон хичээл зохион байгуулах тухай танилцуулга бэлтгэн, танилцуулж, төслийн сургалтаас сурсан мэдсэн туршлагаа хуваалцсан.

**Үйл ажиллагаа 2.** “Мини” хичээл зохион байгуулах ”Дүрд тоглох” аргачлал боловсруулан турших:

*Алхам 1.* “Мини” хичээл зохион байгуулах ”Дүрд тоглох” аргачлалаа оюутнуудад танилцуулах.

*Алхам 2.* Оюутан бүр заах хичээлийн сэдэв, хичээл заах өдөр, цагаа семинарын

бүлгээрээ хэлэлцэн, тохироод баталгаажуулсан жагсаалт гаргаж багшид өгөх.

*Алхам 3.* Семинарын хичээлийн багшийн зүгээс бага боловсролын “Хүн ба нийгэм” хичээлийн сурах бичгээс оюутан багшид хичээл заах сэдвийн жагсаалтыг санал болгох

*Алхам 4.* Оюутан хичээл зохион байгуулах төлөвлөлт гаргасан байх

*Алхам 5.* Ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулан хичээлээ заахаас хамгийн багадаа 2 хоногийн өмнө багшид шалгуулж зөвлөгөө авсан байх

#### Хүснэгт 1. “Мини” хичээл зохион байгуулах ”Дүрд тоглох” аргачлал

№	Дүрийн нэр	Үүрэг, оролцоо	Дүрд тоглохдоо анхаарах зүйлс
1	Багш	Хичээл заах: Агуулга, арга зүй, үнэлгээ, сургалтын орчин зэрэгт ялгаатай байдлыг харгалзан хичээлийг төлөвлөн чиглүүлэн удирдах	1. Тухайн дүрийнхээ байр сууринаас хичээлд оролцон дүгнэлт хийнэ. 2. Хичээлд оролцсон бүх оюутнууд хичээлийн төгсгөлд хичээл заасан оюутан багшийн хичээлийг үнэлж санал болгож буй дүнгээ үнэлгээний хуудсанд бөглөн семинарын хичээлийн багшид өгнө.
2	Сурагч	Хичээллэх, суралцах: Суралцагчийн нас, бие, сэтгэхүйн онцлогийг тооцоолон хичээлд бага насны хүүхдийн үүднээс хандах	3. Хичээл бэлдэн заасан оюутан багш өөрийнхөө зохион байгуулсан хичээлийг үнэлэн, өөрийн үнэлгээний хуудсаа багшид өгнө.
3	Сургалтын менежер	Зөвлөн туслах, удирдлагаар хангах: Багшийн зааж буй хичээлийг ажиглан, тэмдэглэл хөтлөх, хичээлийн хэлэлцүүлэгт оролцон санал, зөвлөмж өгч зөвлөн туслах	4. Семинарын удирдагч багш нийт ирсэн дүнгийн хуудсыг нэгтгэн нэгдсэн үнэлгээг гарган танилцуулж бүлгээрээ хэлэлцэн үнэлгээг баталгаажуулна.
4	Ажиглагч багш-1	Хичээлийн судалгаа хийж, хамтран ажиллах: Багшийн заасан хичээлийг ажиглан, тэмдэглэл хөтлөх, арга зүйн зөвлөгөө өгөх, харилцан суралцах, хичээлийн хэлэлцүүлэгт оролцон санал бодлоо солилцож, хичээлийг үнэлэх	
5	Ажиглагч багш-2 Н/А	Хичээлд ажиглалт хийх, хамтран ажиллах: Хичээлд суух, орчныг үнэлэх шалгах хуудас гэх мэтийг бэлдсэн байх, ялангуяа хичээллэх үеийн сургалтын орчин, нөхцөл байдалд ажиглалт хийх, шийдэх арга зам, боломжийг эрэл хийн санал, зөвлөгөө өгөх	
6	Семинарын хичээлийн чиглүүлэгч багш	Хичээл ажиглах, чиглүүлэх: Хичээлийг бүхлээр нь ажиглах тэмдэглэл хөтлөх, санал зөвлөмжөөр хангах, хичээлийн төгсгөлд хийдэг хэлэлцүүлгийг удирдах, хичээлийг хамтран үнэлэх	

**Үйл ажиллагаа-3.** Оюутан багш нарын хичээл заах үйл явц

*Алхам 1.* Хичээлд оролцож байгаа бүх хүмүүс идэвх санаачилгатай оролцох талаар өмнө нь тохиролцсон тухайгаа сануулсан.

*Алхам 2.* Бүх оролцогч нар өөрсдийн дүрдээ бүрэн орж хичээллэх.

Алхам 3. Оюутан багш төлөвлөсөн хичээлээ зааж дуусах.

Алхам 4. Хичээлийн төгсгөлд багшлах ур чадвар, арга зүйг дээшлүүлэх хичээлийн хэлэлцүүлэг хийх үе

Алхам 5. Хүн бүр хичээл ажиглалтын хуудас хөтөлсөн байх

Алхам 6. Оролцогч бүр хичээлийг дүгнэхдээ дараах гол зарчмыг баримтлан хичээлийг дүгнэсэн байдлаа илэрхийлнэ. Үүнд:

- Хичээлийн давуу тал
- Хичээлийн сул тал
- Хичээлийг сайжруулж арга зам, боломж, санал
- Ялгаатай байдлыг хэрхэн харгалзаж хичээлээ заасан талаар /агуулга, арга зүй, үнэлгээ, орчин гэх мэт/

Алхам 7. Хичээлийн хэлэлцүүлэгт оролцогчид дараах дарааллын дагуу илтгэнэ. Үүнд:

- Хичээл заасан багш
- Хичээлд суусан сурагчдын төлөөлөл /4-5 сурагч/
- Хичээл ажиглагч багш-1
- Хичээл ажиглагч /харьцуулан ажиглагч/ багш-2
- Сургалтын менежер
- Хичээлийг чиглүүлж буй мэргэжлийн багш

Ийнхүү оюутнууд маань төлөвлөн зааж, хичээлийн хэлэлцүүлгийг маш үр дүнтэй зохион байгуулж чадсан гэж үнэлсэн. Энэ талаар хичээлийн төгсгөлд оюутнуудаас авдаг хичээлийн хөтөлбөр сайжруулах санал асуулга дээр ихэнх оюутнууд өндрөөр үнэлсэн явдал нь суралцагчдын ялгаатай байдлыг харгалзан “Мини” хичээл зохион байгуулах аргыг туршсан туршилт хичээлийн үр дүн гэж дүгнэсэн.

Фото зураг 1. ”Мини” хичээлийн үйл явц



Оюутан хичээлийн сэдэв /хамтрагч/, хичээл заах цаг хугацаагаа сонгосон байх ёстой. Хэрэв хүндэтгэн үзэх шалтгаанаар хичээлийг цагт нь зохион байгуулах боломжгүй болсон тохиолдолд семинарын багшид болоод бүлгийн оюутнуудад

мэдэгдэн цагаа солих боломж олгоно, харин шалтгаангүйгээр хичээлийг цагт нь заагаагүй тохиолдолд хамт олноороо хэлэлцэн шийдвэрлэх талаар харилцан хэлэлцээд тохирсон болно. Энэ нь хувь хүний хариуцлага, зохион байгуулалт, цаг ашиглалт, аман гэрээ мөн уян хатан байдал гэх зэргийн олон зүйлтэй холбоотой бөгөөд энэ соёлыг төлөвшүүлснээр хичээлийн чанарт сайнаар нөлөөлсөн гэж дүгнэж байна.

“Мини” хичээлийг туршин зохион байгуулж байхад олон сайхан шинэлэг санал, санаачилга, арга зүйг оюутнууд гаргаж ирж байсан. Онцлон авч үзэхэд багш нар хичээлээ зохион байгуулахдаа анги зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрхэн хийж байгаагаас хичээлийн чанар үр өгөөж ихээхэн шалтгаалж байгааг ажигласан олон оюутнууд дүгнэлт хийж байсан юм. Энэ нь мөн бидний сонгон суралцах хичээлийн жагсаалтад байгаа Тогтвортой хөгжил ба жендэр хичээлийг судалж байсан оюутнуудтай холбоотой байсан нь ажиглагдаж байлаа.

Туршилт хичээлийн өмнөх нөхцөл байдал: Нийт оюутны 71 хувь нь суралцагчдын ялгаатай байдлын талаар огт мэдэхгүй, 20 хувь нь бага зэрэг мэднэ, 8 хувь нь жендэр ба тогтвортой хөгжил хичээл судлах явцдаа мэддэг болсон тухай өгүүлсэн. Мөн агуулга, арга зүй, үнэлгээ, сургалтын орчныг суралцагчдын ялгаатай байдлыг харгалзан зохион байгуулах арга зүйд суралцах хүсэл сонирхолтой байгааг илэрхийлсэн тул туршилт хичээлийг зохион байгуулсан болно.

хичээлийн сэдэв /хамтрагч/, хичээл заах цаг хугацаагаа сонгосон байх ёстой. Хэрэв хүндэтгэн үзэх шалтгаанаар хичээлийг цагт нь зохион байгуулах боломжгүй болсон тохиолдолд семинарын багшид болоод бүлгийн оюутнуудад мэдэгдэн цагаа солих боломж олгоно, харин шалтгаангүйгээр хичээлийг цагт нь заагаагүй тохиолдолд хамт олноороо хэлэлцэн шийдвэрлэх талаар харилцан хэлэлцээд тохирсон болно. Энэ нь хувь хүний хариуцлага, зохион байгуулалт, цаг ашиглалт, аман гэрээ мөн уян хатан байдал гэх зэргийн олон зүйлтэй холбоотой бөгөөд энэ соёлыг төлөвшүүлснээр хичээлийн чанарт сайнаар нөлөөлсөн гэж дүгнэж байна.

## Судалгааны үр дүн

Туршилт хичээлийн үр дүн: Хичээлийн нийт 16 семинарын 13 удаагийн хичээлийг “МИНИ ” хичээл зохион байгуулах аргаар зохион байгуулсан. Энэ туршилт хичээлийг зохион байгуулахад олон давуу тал ажиглагдсан ч сайжруулах, цаашид анхаарах зүйлүүд ч байсныг тэмдэглэх нь зүйтэй. Үүнээс зарим зүйлүүдийг дүгнэн үзвэл: Өмнө нь семинарын хичээлийг зохион байгуулахдаа сайн дурын үндсэн дээр, сонголтын боломж зэргийг оргодог байсан хэдий ч багаар ажиллах аргачлал боловсруулж, оюутнуудад танилцуулж, өөрсдөөр нь хэлэлцүүлж батлуулан, хичээл дээр баримтлах дүрэм, дэгийн талаар анхаарч байгаагүй дутагдал байсан нь тодорхой байна. Уг туршилт хичээлийн явцад улам олон санаанууд багшийн болон оюутны зүгээс гарч хичээлийн туршид сайжруулж байсан. Туршилт хичээлийг эхлэхийн өмнө:

- Хувь хүний сонирхол
- Суралцах ялгаатай хэв шинж
- Хамтран ажиллах сонголтыг бий болгох зэрэгт анхаарлаа хандуулсан зэрэг нь нэлээд үр өгөөжтэй байсан.

Туршилт хичээл явагдсан танхим нь нэг боловч /Багшийн сургуулийн 102 тоот/ бүлэг тус бүрийн хичээлээ зохион байгуулах зохион байгуулалт нь ялгаатай байсан нь дараах давуу талтай байв. Үүнд:

- 1) 4-1 бүлэг нийт 27 оюутантай бөгөөд А- баг 14 гишүүнтэй, Б- баг 16 гишүүнтэй хоёр том багт хуваагдан оюутан бүр ганц ганцаараа хичээлийг заах ба ангид А болон Б багт 2 багш зэрэг хичээл заана. 2 багийн гишүүд “Мини” хичээл зохион байгуулах дүрд тоглох аргаараа хичээлийг өөр өөрийн оногдсон дүрдээ орж ээлжлэн хичээлийг зохион байгуулж байсан.
- 2) 4-2 бүлэг нийт 26 оюутантай байсан ба хоёр хоёроороо баг болж хичээлээ хосоороо хамтран заасан бөгөөд ингэхдээ танхимд хоёр багш нэг зохион байгуулалтаар хичээлийг явуулж байсан.
- 3) “Мини” хичээл зохион байгуулахдаа “Дүрд тоглох” аргаар 1-2 дамжааны оюутнуудад хичээл зохион байгуулахад тохиромжгүй. Харин 3-4 дамжааны оюутнуудад аль ч арга зүйн хичээлийг зохион байгуулахад илүү тохиромжтой нь илэрхий ажиглагдлаа.
- 4) Хичээлд хамрагдсан оюутнууд хичээлээ дүгнэн ярихдаа энэ аргаар хичээлийг зохион байгуулснаар бусдаасаа олон зүйлийг сурсан ба багшид байх хамгийн чухал чадваруудыг олж авах гэж хичээлээ. Сайжруулах хэрэгцээтэй байгаа чадваруудаа ч мэдэрлээ, төгсөх ангийнхан учир үлдсэн хугацаандаа зорилго тавин ажиллах тухайгаа мөн суралцагчдынхаа бүх төрлийн ялгаатай байдлыг харгалзан багш агуулга, арга зүй, үнэлгээ, орчин, хэрэглэгдэхүүн зэргээрээ шийдэж болох боломжийг мэдэж, яаж шийдэх арга замаа тодорхойлж чаддаг болсон төдийгүй ялгаатайд ялгаатай хандах хандлагад ихээхэн өөрчлөлт гарч, бие биетэйгээ ойлголцох, хамтран ажиллах, харилцан суралцахад олон эерэг нөлөөлөл бий болсон тухай оюутан бүр илэрхийлж байсан явдал хамгийн чухал байсан гэдгийг нэгтгэн дүгнэж байна. (Хавсралт 3. Эргэцүүлэл)

## Дүгнэлт

Багш нар хичээлийн эхэнд суралцагчдынхаа ялгаатай байдлыг оношилж, илрүүлэн, хичээлээ төлөвлөх аргад суралцах нь зайлшгүй чухал гэдгийг Ховард Гарднерийн оюун ухааны цогц хөгжлийн сорилыг хэрэглэсэн туршилт судалгаанаас харж болохоор байна. Оюутан багш нар “Мини” хичээл зохион байгуулахдаа “Дүрд тоглох” аргаар хичээлийг сайн бэлтгэж, хичээлийн алхам бүрийг нарийн тооцож, тогтмол, чанар сайтай зааж, хичээлийн хэлэлцүүлгийг тогтмол чанартай зохион байгуулснаар суралцагчид нийтээрээ өөрчлөгдөж, семинарын хичээлийн идэвх, сурч хөгжих хэрэгцээ сонирхол эрс нэмэгдсэн болох нь судалгаанаас харагдаж байна.

Тиймээс бүх шатны боловсролын багш нар ялгаатайд ялгаатай хандах хандлагыг чухалчлан хүүхэдтэй ажиллах арга зүйдээ нэвтрүүлэх нь чухал байна. Багш сурган хүмүүжүүлэгчид хичээл, сургалтын ажлаа үр өгөөжтэй явуулах, бодит үр дүнд хүрэхийн тулд сурагчдын онцлог хэв шинж, ялгааг сургалтын явцад харгалзан, үүнд тохирсон арга барил сонгох нь чухал болоод байгааг түгээн дэлгэрүүлэх нь багш бэлтгэдэг сургуулийн багш нарын хувьд нийгмийн хариуцлага болох нь тодорхой байна.

## **Ном зүй**

Англи хэлээр

Sternberg, R. (1984). Toward a triarchic theory of human intelligence. *Behavioral and Brain Sciences*, 7, 269-287.

Tomlinson, C. A. (2001). *Assessment and Student Success in a Differentiated Classroom*.

Hobson, A (2013). Teacher fabrication as an impediment to professional learning and development: the external mentor antidote. *Oxford Review of Education*, 39 No.3, 345-365

Valiandes, A.S. (2010). *Application and Evaluation of Differentiated Instruction in Mixed Ability Classrooms*. Doctoral Dissertation University of Cyprus (In Greek).

Монгол хэлээр

Жадамба, Б ба бусад. (2022). Суралцагчдын ялгаатай байдлыг харгалзсан сургалт. Улаанбаатар.

Жадамба, Б ба бусад. (2022). Суралцагчдын ялгаатай байдлыг харгалзсан анги танхимын менежмент. Улаанбаатар.

**IMPLEMENTING A “MINI” LESSON METHOD THAT ACCOUNTS  
FOR STUDENT DIFFERENCES  
(An Example from the Social Science Methodology Course  
at the Teacher School)**

<sup>a</sup>Uriintuya N

<sup>a</sup>Master, Lecturer, Teachers School, MNUE

Corresponding author: [uuriintuya@msue.edu.mn](mailto:uuriintuya@msue.edu.mn) 

**Abstract**

This article aims to present the results of implementing and testing a “Mini” lesson method in the “Human and Society” social science methodology course at the Teachers’ School, focusing on student characteristics, interests, and individual differences. The study involved a total of 53 fourth-year students from two groups in the primary education program. Emphasizing the importance of addressing each student’s individual differences, the study highlights the use of Howard Gardner’s multiple intelligences test as essential for identifying learner differences.

The findings reveal that effectively organizing “Mini” lessons with role-playing, careful planning, structured teaching, and engaging discussions is key to successful implementation. Within the framework of this goal, it is noted that, in order to enhance the quality and effectiveness of education today, it is important to implement lessons and activities that consider each learner’s differences. This aligns with global trends and the theories and concepts proposed by researchers and scholars, suggesting possibilities for incorporating these approaches into educational activities.

**Keywords**

Differentiating instruction, The mini lesson, Learning model, Gender-responsive lesson planning Social and cultural diversity, Learning style differences